



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН
ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН ЗАХИРАМЖ**

2019 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 182/ШШ2019/00277

Улаанбаатар хот

Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан болохыг баталж,
хэргийг хэрэгсэхгүй болгох тухай

Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Т.Наранцогт би,

Нэхэмжлэгч: Сүхбаатар дүүрэг, 5 дугаар хороо, Үндсэн хуулийн гудамж, “Ньюмаинд групп” ХХК-ийн байранд байрлах 5039754 регистрийн дугаартай “Лэндмн ББСБ” ХК-ийн нэхэмжлэлтэй,

Хариуцагч: Чингэлтэй дүүрэг, 17 дугаар хороо, Сурагчийн 7 дугаар гудамж, 67е тоотод оршин суух ВД91071905 регистрийн дугаартай Бэсүд бариач овогт Норовжавын Билэгт-Отгонд холбогдох,

Зээлийн гэрээний үүрэгт 167,431 төгрөг гаргуулах тухай иргэний хэргийг хүлээн авч хянаад

ТОДОРХОЙЛОХ нь:

Нэхэмжлэгчийн төлөөлөгч /захирал/ Б.Дэлгэржаргал шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ: Норовжавын Билэгт-Отгон нь Монгол улсын “Иргэний хууль”, “Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль” болон өөрийн хүсэлтийн дагуу “Лэндмн ББСБ” ХК-тай 2017 оны 12 сарын 04-ний өдөр 11092 дугаартай Цахим зээлийн эрх нээх гэрээг байгуулсан билээ.

“Лэндмн ББСБ” ХК зээлдэгч Н.Билэгт-Отгонгийн LendMN аппликейшнээр дамжуулан гаргасан хүсэлтийн дагуу 2017 оны 12 сарын 05-ны өдөр 140,000 /нэг зуун дөчин мянга/ төгрөгийн зээлийг 12,700 төгрөгийн шимтгэлтэй, 30 хоногийн хугацаатай, 2018 оны 01 сарын 04-ний өдөр бүрэн эргэн төлөх нөхцөлтэй, олгож нийт 140,000 төгрөгийг Н.Билэгт-Отгоны Төрийн банкны 105000316898 тоот дансанд шилжүүлсэн.

Зээлдэгч Н.Билэгт-Отгон нийт үндсэн зээлийн дүн болох 140,000 төгрөг, шимтгэл болох 12,700 төгрөгийг өнөөдрийг хүртэл төлөөгүй байгаа юм. Зээлдэгч нь зээлийн гэрээний 4.2.2 заалтыг зөрчин, зээлийг хугацаанд нь эргэн төлөх үүргээ биелүүлээгүй байна.

Н.Билэгт-Отгоныг гэрээний үүргээ биелүүлэх, зээлээ төлөхийг удаа дараа шаардсан боловч эргэн төлөлтийг өнөөдрийг хүртэл төлөөгүй байгаа тул хариуцагч Н.Билэгт-Отгоноос үндсэн зээлийн төлбөр 140,000 төгрөг, зээлийн шимтгэл 12,700 төгрөгийг гаргуулах хүсэлтэй байна.

Иймд хариуцагч Н.Билэгт-Отгоноос үндсэн зээлийн төлбөр 140,000 /нэг зуун дөчин мянга/ төгрөг шимтгэл 12,700 төгрөг /арван хоёр мянга долоон зуу/ төгрөг, нотариатын үйлчилгээний төлбөр 14,731 төгрөг /арван дөрвөн мянга долоон зуун гучин нэг/ мөнгө буюу нийт 167,431 /нэг зуун жаран долоон мянга дөрвөн зуун гучин нэг/ мөнгийг гаргуулж өгнө үү гэжээ.

Нэхэмжлэгчийн төлөөлөгч А.Билгүүн шүүхэд гаргасан хүсэлтдээ: хариуцагч Н.Билэгт-Отгон нь манай компаниас 2017 оны 05 сарын 12-ны өдөр авсан 140,000 төгрөгийн үндсэн зээл, 12,700 төгрөгийн шимтгэл болох нийт 152,700 төгрөгийг барагдуулж дуусан тул шүүхэд гаргасан нэхэмжлэлээсээ татгалзаж байгаа болно гэжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

“Лэндмн ББСБ” ХК нь Н.Билэгт-Отгонд холбогдуулан Зээлийн гэрээний үүрэгт 167,431 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэлийн шаардлага гаргасан ба хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэгчийн төлөөлөгч А.Билгүүн нь хариуцагч Н.Билэгт-Отгоныг нэхэмжлэлийн шаардлага болох 167,431 төгрөгөөс 152,700 төгрөгийг төлж барагдуулсан үндэслэлээр түүнд холбогдуулан гаргасан нийт нэхэмжлэлийн шаардлагаасаа татгалзсан байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-т зааснаар нэхэмжлэгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд нэхэмжлэлээсээ татгалзах эрхтэй тул нэхэмжлэгчийн төлөөлөгчийн гаргасан хүсэлтийг хүлээн авах боломжтой гэж үзлээ.

Нэхэмжлэгч “Лэндмн ББСБ” ХК нь бүх шатны шүүхэд төлөөлөх, нэхэмжлэлээс татгалзах эрхийг А.Билгүүнд 2019 оны 01 сарын 24-ний өдөр 6 сарын хугацаатай итгэмжлэлээр олгосон бөгөөд тус итгэмжлэл хүчин төгөлдөр байна.

Ийнхүү нэхэмжлэгч нь нэхэмжлэлээсээ татгалзсан нь хууль зөрчөөгүй, гуравдагч этгээдийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хөндөөгүй байх тул нэхэмжлэгчийн татгалзлыг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох нь зүйтэй байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2, 75 дугаар зүйлд заасныг тус тус удирдлага болгон

ЗАХИРАМЖЛАХ нь:


1. “Лэндмн ББСБ” ХК-ийн нэхэмжлэлтэй Н.Билэгт-Отгонд холбогдох Зээлийн гэрээний үүрэгт 167,431 төгрөг гаргуулах тухай иргэний хэргийн нэхэмжлэгчийн төлөөлөгч А.Билгүүн нь нэхэмжлэлийн шаардлагаасаа татгалзсныг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгосугай.

2. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5, 74

дүгээр зүйлийн 74.5 дахь хэсэгт зааснаар нэхэмжлэгч “Лэндмн ББСБ” ХК-ийн улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 5,672.93 төгрөгийн 2,836 төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээж, улсын төсвийн данснаас 2,836 төгрөгийг гаргуулж нэхэмжлэгчид олгосугай.

3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.4-т зааснаар зохигч давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах, тухайн асуудлаар анхан шатны шүүхэд дахин нэхэмжлэл гаргах эрхгүй болохыг дурдсугай.

ШҮҮГЧ



Т.НАРАНЦОГТ